

ӨНДӨРХААН ХК

2024 оны 07 сарын 30-ний өдөр

№24/07

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлыг хойшлуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, 59.10, 69 дүгээр зүйлийн 69.3, 69.4, 69.6, 69.7, 76 дугаар зүйлийн 76.1.2, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өндөрхаан ХК-ийн 2024 оны 07 сарын 25-ны өдрийн 15:00 цагт болсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц хүрээгүй тул 2024 оны 08 сарын 21-ний өдрийн 15:00 цагт цахим хэлбэрээр дахин хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 07 сарын 30-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хойшлогдсон тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн дотор нийтэд зарласугай.
6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, зэрэг холбогдох бусад баримт бичгийг бэлэн болгож, 2024 оны 08 сарын 07-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.
8. Хурлын даргаар Өндөрхаан ХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Цогбадрахыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Ө.Ашхүү

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

М.Мөнхбадрал

ӨНДӨРХААН ХК

С.Дэлгэржаргал

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

Ө.Бямбагэрэл

Гишүүд

Г.Сэлэнгэ

11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурал зохион байгуулж, зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахад шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн С.Дэлгэржаргалд даалгасугай.

ДАРГА



Г.ЦОГБАДРАХ